ТӨВ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2023/10/НА-СТА-ОНА

ЗУУНМОД ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод хот 2023 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан 7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 10
3.1 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа 10
3.2 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт 11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл 12
4. АУДИТЫН ТАЙЛАН 12
4.1 Ерөнхий зүйл 13
4.2 Материаллаг байдал 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
4.5.1 Завсрын аудитын талаар 15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 16
5.1 Төлбөрийн акт 16
5.2 Албан шаардлага 16
5.3 Зөвлөмж 16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 18
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл 18
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 19
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 20

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИТХТХ	Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хурал
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023·03·16 № 01/217.
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД
ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ЖАРГАЛЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 103 дугаар тогтоолоор Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ыг байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр гүйцэтгэх захирал Б.Жаргалцэцэгтэй "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Зуунмод сумын 2022 оны А/117 дугаар захирамжаар нь Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлийг байгуулсан.

Засаг даргын тамгын газраас 273,222.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Зуунмод сумын Засаг даргыг төлөөлж Засаг даргын тамгын газрын дарга нь Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний, төлөвлөгөөг 175,000.0 мянган төгрөгийн орлоготой, 175,000.0 мянган төгрөгийн зардалтай ажиллахаар

19020359

баталснаас 229,906.8 мянган төгрөгийн орлоготой, 223,943.4 төгрөгийн зардал гаргаж, 5,963.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын 2022 онд байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээнд тусгагдсан 22 үүргийн биелэлт 100.0 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	2,580,355.13
1.1.2	Дансны авлага		
1.1.6	Бараа материал	-	17,422,561.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		608,000.00
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**-**	**20,610,916.86**
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		279,928,118.15
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	-	279,928,118.15
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**-**	**300,539,035.01**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**		
2.1	Өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		9,428,887.50
2.1.1.2	Цалингийн өглөг		22,815.60
2.1.1.3	Татварын өр		5,332,588.90
2.1.1.4	НДШ-ийн өр		2,165,313.92
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		5,000,000.00
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**-**	**21,949,605.92**
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		273,222,395.00
2.1.2.5			
2.1.2.6	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**-**	**273,222,395.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**-**	**295,172,000.92**
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч - төрийн	-	-
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг		5,367,034.10
2.3.10	Тайлант үеийн ашиг		5,367,034.10
2.3.11	Эздийн өмчийн дүн	**-**	**5,367,034.10**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**-**	**300,539,035.01**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	51,052,942.73
2	Борлуулалтын өртөг		40,864,058.88
3	**Нийт ашиг (алдагдал)**	**-**	**10,188,883.85**
8	Бусад орлого		178,853,844.55
9	Борлуулалт, маркетингийн зардал		779,373.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	182,299,984.18
18	**Татварын өмнөх ашиг (алдагдал)**	**-**	**5,963,371.22**
19	Орлогын татварын зардал		596,337.12
20	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
21	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**-**	**5,367,034.10**
22	**Бусад дэлгэрэнгүй орлого**	**-**	**-**
24	**Орлогын нийт дүн**	**-**	**5,367,034.10**
25	**Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)**		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**-**	**-**	**-**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	**-**
Залруулсан үлдэгдэл	**-**	**-**	**-**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	**-**	**5,367,034.10**	**5,367,034.10**
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**-**	**5,367,034.10**	**5,367,034.10**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	**-**	**233,345,470.00**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		56,453,270.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Буцаан авсан албан татвар		
1.1.4	Татаас, санхүүжилтийн орлого		170,050,800.00
1.1.5	Бусад мөнгөн орлого		6,841,400.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**-**	**221,836,114.87**
1.2.1	Ажиллагсдад олгосон мөнгө		92,917,361.37
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад олгосон мөнгө		24,855,317.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө		75,880,190.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө		601,130.61
1.2.5	Шатахуун, тээврийн зардалд төлсөн мөнгө		11,915,560.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн мөнгө		-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн мөнгө		3,212,632.56
1.2.8	Даатгалын байгууллагад төлсөн мөнгө		387,175.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага		12,066,748.29
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**-**	**11,509,355.13**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	**-**	**-**
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**-**	**8,929,000.00**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		8,929,000.00
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**-**	**(8,929,000.00)**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	**-**	**-**
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	**-**	**-**
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**-**	**-**
4	**Гадаад валютын зөрүү**	**-**	-
5	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**-**	**2,580,355.13**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		
7	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**-**	**2,580,355.13**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Эдийн засгийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
ОРЛОГЫН ДҮН	**175,050,800.00**	**229,906,787.73**	**54,855,987.73**	131.3
Төсвийн санхүүжилт	170,050,800.00	170,050,800.00	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	5,000,000.00	52,280,797.73	47,280,797.73	1,045.6
Хандив тусламж	-	5,563,000.00	5,563,000.00	-
Төсөл хөтөлбөр	-	2,012,190.00	2,012,190.00	-
УРСГАЛ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН	**175,000,000.00**	**223,943,416.06**	**(48,943,416.06)**	**128.0**
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	117,037,200.00	113,397,879.00	3,639,321.00	96.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,323,760.00	14,079,761.40	(756,001.40)	105.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,665,000.00	923,360.00	2,741,640.00	25.2
Бичиг хэрэг	1,144,000.00	1,737,160.00	(593,160.00)	151.8
Тээвэр шатахуун	7,680,000.00	12,981,622.95	(5,301,622.95)	169.0
Шуудан холбоо	1,020,000.00	798,563.00	221,437.00	78.3
Хангамжийн материал	-	9,189,811.00	(9,189,811.00)	-
Нормын хувцас зөөлөн эдлэл	3,040,000.00	2,930,000.00	110,000.00	96.4
Цэвэрлэгээ халдвар хамгааллын зардал	1,100,000.00	169,550.00	930,450.00	15.4
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,520,000.00	1,121,500.00	398,500.00	73.8
Багаж техник хэрэгсэл	11,819,000.00	1,211,653.00	10,607,347.00	10.3
Тавилга эд хогшил	6,002,000.00	-	6,002,000.00	-
Компьютер тоног төхөөрөмж	-	2,701,199.00	(2,701,199.00)	-
Урсгал засвар,сэлбэг хэрэгсэл	6,200,000.00	14,373,725.00	(8,173,725.00)	231.8
Сэлбэг хэрэгсэл	-	2,518,909.00	(2,518,909.00)	-
Дотоод албан томилолт	500,000.00	144,000.00	356,000.00	28.8
Татварын хураамж	-	77,500.00	(77,500.00)	-
Аудитын төлбөр	400,000.00	588,000.00	(188,000.00)	147.0
Даатгалын үйлчилгээ	376,000.00	387,175.00	(11,175.00)	103.0
Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	-	27,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	33,000.00	33,000.00	50.0
Тээврийн хэрэгслийн даатгал	81,000.00	-	81,000.00	-
Хөтлөгчийн үнэ	-	200,000.00	(200,000.00)	-
Ажлын хөлс	-	43,000.00	(43,000.00)	-
Сэлбэг /тээвэр/	-	250,000.00	(250,000.00)	-
Цэцэрлэгжүүлэлтийн зардал	-	1,759,500.00	(1,759,500.00)	-
Банкны гүйлгээний хураамж	-	130,500.00	(130,500.00)	-
Программ хангамж	-	180,000.00	(180,000.00)	-
Бусад зардал	-	50,000.00	(50,000.00)	-
Барилга байгууламж	-	183,478.00	(183,478.00)	-
Тээврийн хэрэгсэл	-	139,136.00	(139,136.00)	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	40,864,058.88	(40,864,058.88)	-
Борлуулалт маркетингийн зардал	-	779,374.82	(779,374.82)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Зуунмод цэцэрлэгжүүлэлтОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын зорилго нь: “Зуунмод сумын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжит орчныг нэмэгдүүлэх, шинээр бий болгох, эрүүл аюулгүй, стандартад нийцсэн таатай орчныг бий болгож иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллах” гэж тодорхойлжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГазар статустай Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын харьяа байгууллага байна.

Үйлдвэрийн газрын дүрэмд ” Газрын /ОНӨААТҮГ-ын өмчлөгч нь Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь сумын Засаг даргаас эрх олгосон газар байна.” гэж тодорхойлжээ.Үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хариуцсан газрын болон нийтийн эзэмшлийн мод бут, цэцэг зүлгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж амьдралын хувийг нэмэгдүүлж, усалгаа, арчилгаа, намрын цэнэг усалгааг хариуцах;
- Мод бутны үр үрслэгээ ургуулж өсгөж, шилжүүлэн суулгах;
- Цэцгийн ургамлын үрсэлгээ ургуулж өсгөж, шилжүүлэн суулгах;
- Мод бутны гэрэлтүүлэг, хашаа хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хариуцах;
- Хашаандаа мод тарьсан болон тарих иргэдэд усалгаа болон бусад хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх;
- Зуунмод сумын иргэдэд мод бут, цэцэг тарих, арчлах ургуулах, шилжүүлэн суулгах чиглэлээр сургалт, зөвлөгөө зөвлөмжийн үйлчилгээ үзүүлэх ;
- Жил бүрийн хавар намрын улиралд хариуцсан газарт ургаж амьдарч буй модны тоо, амьдралтын хувийг тооцон гаргаж нөхөн тарих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;
- Газрын бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.2 Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын *үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:*

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ыг Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 103 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4-т”Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.;...” гэсэн заалттай нийцэж байна.

"Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Тайлант хугацаанд Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна.Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.

- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д” Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөгүй байна.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын захирлын 2022 оны А/07 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалт хийх багийг 3 ажилтны бүрэлдэхүүнтэй томилсон байна. Дотоод хяналтын багийн ажиллах журам, ажлын төлөвлөгөөг батлаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, заавар журмыг бүрэн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх ”Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй НББББББ-ийг баримт бичигт өөрчлөлт ороогүй байна..

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 300,539.0 мянган төгрөгөөр буюу 100.0 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,580.3	2,580.3
Авлага	-	-	-
Бараа материал	-	17,422.6	17,422.6
Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	608.0	608.0
Үндсэн хөрөнгө	-	279,928.1	279,928.1
Нийт хөрөнгө	**-**	**300,539.0**	**300,539.0**
Өр төлбөр	-	295,172.0	295,172.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	5,367.0	5,367.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**-**	**300,539.0**	**300,539.0**

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс өссөн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,580.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс нөлөөлсөн.
- Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 17,422.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс нөлөөлсөн.
- Үндсэн хөрөнгө 279,928.1 Зуунмод сумын засаг даргын тамгын газраас 209,741.4 мянган төгрөгийн барилга байгууламж, 63,481.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 6,336.2 мянган төгрөгийн компьютер авч, 4,235.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос нөлөөлсөн.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 813.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашгийн бүртгэж тайлагнаснаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын захирал Зуунмод сумын засаг даргатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нэгдүгээр хавсралтаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 175,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 175,000.0 мянган төгрөгөөр алдагдалгүй ажиллахаар тогтоосон байна..

Нийт орлогын гүйцэтгэл 229,906.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 54,856.0 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар давж биелсэн нь Үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 223,943.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 48,943.4 мянган төгрөгөөр илүү буюу 128.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааг сайжруулах ,төрийн хэмнэлтийн хуультай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, Г.Ариунболд аудиторын туслах З.Ариунцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-нь 2022 оны санхүүгийн тайлангаа Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **Дунд** гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 224,539.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,245.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,571.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар баталсан бодлого чиглэл гаргаж батлаагүй байна. Нийт батлагдсан 16 орон тоо баталснаас 14 орон тоотойгоор 2 орон тоо, дутуу ажиллаж, 15,588.5 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 16 төрлийн 157 мэдээлэл байршуулахаас 107 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 49 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 3 удаагийн орлогын 42,512.7 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т "Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дотоод хяналтын төлөвлөгөө, ажиллах журамгүй, дотоод хяналт хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>:

Дотоод хяналтын ажиллах журмыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийгдээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг орон нутгийн өмч хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх, эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр нь хуульд нийцэж буй эсэх талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 340,449.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав.Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогод хамаарах худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн 491.3 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг албан татвараас хасаж тооцсоныг;
- Орон нутгийн өмчид бүртгүүлээгүй, Сумын ИХТХ-ийн тогтоолгүй ,сумын засаг даргын тамгын газрын 2022 оны 06/1016 тоот албан бичгийн дагуу үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3 нэр төрлийн 273,222.4 төгрөгийн үндсэн хөрөнгийг эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэж тайлагнасныг;
- Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн орлогод 5,153.1 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж тайлагнасныг;
- Мөнгөн хөрөнгийн харилцах дансны ажил гүйлгээг бүртгэхдээ тооцооны дансанд бүртгэхгүй хөрөнгө болон зардлын дансанд 59,146.3 мянган төгрөгийг, бараа материалын дансанд бүртгээгүй 2,436.0 мянган төгрөгийн бараа материал, нийт 61,582.3 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүйг; тус тус залруулав.

Аудитаар нийт 1 зөрчилд 934.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1 зөвлөмж өгөв.**5.1 Төлбөрийн акт**

Тайлант онд нийт 12 ажилтны ээлжийн амралтын цалинг бодохдоо хоолны олговрыг амралтын цалинд оруулж тооцсоны улмаас 934.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын .2.3.6-д "*Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, норматив*ыг *хэтрүүлэн зарцуулсан*" *заа*сныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитын явцад албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үнэ төлбөргүй хөрөнгийг орлогод авах талаар НББББББ-т заагаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль дүрэмд нийцүүлэн НББББББ-т өөрчлөлт оруулан батлуулж мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлогод хамаарах худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг албан татвараас хасаж тооцсон байна.	1	491.3	1	491.3			1	491.3				
Орон нутгийн өмчид бүртгүүлээгүй, Сумын ИХТХ-ийн тогтоолгүйгээр сумын засаг даргын тамгын газрын 2022 оны 06/1016 тоот албан бичгийн дагуу үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3 нэр төрлийн 273,222.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэж тайлагнасан байна.	1	273,222.4			1	273,222.4	1	273,222.4				
Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн орлогод 5,153.0 мянган төгрөгийн Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж тайлагнасан байна.	1	5,153.0			1	5,153.0	1	5,153.0				
Мөнгөн хөрөнгийн харилцах дансны ажил гүйлгээг бүртгэхдээ тооцооны дансанд бүртгэхгүй хөрөнгө болон зардлын дансанд 59,146.3 мянган төгрөг, бараа материалын дансанд бүртгээгүй 2,436.0 мянган төгрөгийг шууд зардлын дансанд нийт 61,582.3 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй байна.	1	61,582.3			1	61,582.3	1	61,582.3				
Дүн	**4**	**340,449.0**	**1**	**491.3**	**3.0**	**339,957.7**	**4**	**340,449.0**	**-**	**-**	**-**	**-**

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд нийт 12 ажилтны ээлжийн амралтын цалинг бодохдоо хоолны олговрыг амралтын цалинд оруулж тооцсоны улмаас 934.5 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	934.5	1	934.5								
Үнэ төлбөргүй хөрөнгийг орлогод авах талаар НББББББ-т заагаагүй байна	1	-					1	-				
Дүн	**2**	**934.5**	**1**	**934.5**			1	-				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 16 төрлийн 157 мэдээлэл байршуулахаас 107 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 49 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 3 удаагийн орлогын 42,512,700.00 төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байна.	1	42,512.7					1	42,512.7
Дүн	**1**	**42,512.7**					**1**	**42,512.7**
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод хяналтын төлөвлөгөө, ажиллах журамгүй, дотоод хяналт хийгдээгүй байна.	1	-					1	-
Дүн	**1**	**-**					**1**	**-**
Нийт дүн	**2**	**42,512.7**					**2**	**42,512.7**